

## “ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ” ОУБ СЭЛЭНГЭ НУТГИЙН ХӨТӨЛБӨРИЙН

### 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ Нутгийн Хөтөлбөр нь зорилтот 7 сум, 2 тосгон болох Шаамар сум болон Дулаанхаан тосгон, Ерөө сум болон Бугант тосгон, Хүдэр сум, Жавхлант сум, Орхон сум, Сант болон Сүхбаатар сумуудад 3 Техникийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан.

**Өрхийн амьжиргааг дэмжих техникийн хөтөлбөрөөр** дамжуулан өрхийн үйлдвэрлэл болон бизнесийн бүлгүүдийг дэмжих зорилгоор шат дараалсан сургалтуудыг зохион байгуулан өрхийг орлогыг нэмэгүүлэхэд чиглэн ажиллаж байна. Үүнд: Эсгий урлал, оёдол, зөгий, гахай, тахиа, үхэр, гутал засвар, үсчин, гоо сайхан болон жижиг өрхийн үйлдвэрлэл эрхлэх тоног төхөөрөмжөөр хангасан. Үүний үр дүнд өрхүүд орлогын эх үүсвэртэй болсон. Санхүүгийн зөв дадалтай болгох зорилгоор хуримтлалын бүлэгийг байгуулан ажиллаж байна.

#### **Хүүхэд хамгаалал ба оролцоо техникийн хөтөлбөрөөр:**

- Хүүхэд хамгаалалын хамтарсан багийг чадавхжуулах сургалтуудыг цувралаар зохион байгууллаа.
- Гэр бүл рүү чиглэсэн “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, “Баяр хөөртэй гэр бүл”, “Гэрээр айлчлагч” аргачлалуудаар дамжуулан сургалтуудыг эцэг эхчүүд болон асран хамгаалагчид зориулан тогтмол хийж байна.
- “Илүү дээр маргаашийн төлөө” хүүхэд хамгаалалын аяныг Аймгийн Боловсролын газар, ГБХЗХГтай хамтран зохион байгуулж, сургууль, цэцэрлэг, дотуур байр болон бусад байгууллагуудад хүүхдэд ээлтэй орчин бий болгоход дэмжлэг үзүүлэн ажилласан.

**Орон нутгийн оролцоот хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн хүрээнд:** Хүүхдийн оролцоог дуу хоолойг дэмжих зорилгоор хүүхдийн сайн дурын клубууд болон сургуульд суурилсан хүүхдийн оролцооны клубуудад дэмжлэг үзүүллээ.

- Хүүхдийн оролцоо хөгжил хамгаалалыг дэмжин сургуульд суурилсан хөгжлийн клубуудыг дэмжин ажиллаж байна. Одоогийн байдлаар 9 төрлийн клубуудын үйл ажиллагаага дэмжин ажилласан
- Орон нутгийн ИНБ-үүд, иргэдийн бүлгийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Жижиг төсөл” зарлаж нийт 7 төслийг шалгаруулан хэрэгжүүлэн ажилласан.

Энэхүү олон талт төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байгаа зорилтот орон нутгийн сайн дурын идэвхтэнүүд, сургагдсан сургагч багш нар, иргэний нийгмийн байгууллагууд болон иргэд, төрийн байгууллагууд болох аймгийн ЗДТГ, БСУГ, ГБХЗХГ, ОБГ болон зорилтот сумдуудын ЗДТГ, сургуулийн захиргаа, цэцэрлэг болон төрийн бус байгууллагуудадаа талархалаа илэрхийлж байна.

Дэлхийн Зөн Монгол ОУБ, Сэлэнгэ Нутгийн Хөгжлийн Хөтөлбөр

2022 оны 07 сарын 19